

# ЗАЛУУЧУУДЫН ГЭРЛЭЛТ, ГЭР БҮЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

*Т.Бүрэнжаргал*  
*МУИС-ийн Социологийн тэнхмийн багш,*  
*Социологийн ухааны доктор (PhD)*

*In addition to include micro level, family is one of the primary nests of socialization which takes community physiology, courteous. Therefore we need to focus on young couple's life that just married each other. These youth's are being possible to divide by 3 stages. There are beginnings of youths, mid of youths, perfect of youths.*

*Average age of marriage is not same in different countries. This difference involved with many reasons. There are individual's physical factors and economic development of countries and tradition, education of population, term of obtaining education, situation and possibility of independent life, knowledge and profession. Compound family's incensement is one of the specialties of family life.*

Залуу гэр бүлийн асуудлыг хөндөхдөө гэрлэлтийн харилцаанаас эхлэх нь зүйтэй. Үйлдвэрлэлийн харилцаа нь зөвхөн хоёр хүний хувийн хэрэг бус харин илүү өргөн агуулгатай нийгмийн амьдралын чухал харилцаа юм. Тиймээс нийгэмд гарч байгаа өөрчлөлт шинэчлэл гэр бүлийн харилцаанд шууд нөлөөлж байдаг. 1999 онд нийгмийн харилцааны шинэ нөхцөл байдлыг тусгаж баталсан Монгол улсын Үр бүлийн хуулинд "гэр бүл нь гэрлэлтийн үр дүнд бий болсон эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг хэлнэ" хэмээн тодорхойлсон бөгөөд гэрлэлт ба цуцлалт, өмчийн болон хүүхдийн асуудал, гэр бүл дэх зөрчил маргааныг хэрхэн шийдвэрлэх асуудлуудыг хуульчлан заасан. Үр бүл нийгмийн бичил орчныг бүрдүүлэхээс гадна бие хүний тав тухтай амьдрал, хамтын сэтгэл зүй, хүмүүжил төлөвшил, нийгэмшилт тасралтгүй явагддаг анхдагч үүр болдог учраас гэр бүлийн амьдралд хөл тавьж байгаа залуу гэр бүлийн асуудалд анхаарлаа хандуулах нь чухал юм. Залуучуудын гэрлэлт, залуу гэр бүлийн асуудал нь гэр бүлийн социологийн зайлшгүй судлагдахууны нэг болдог.

Монгол улсын хүн амын 66 хувийг 0-30 нас хүртэлх хүүхэд, залуучууд эзэлж, нийгэмд идэвхтэй байр сууриа хадгалсаар байгаа бөгөөд энэ нь хүн амын нөхөн үйлдвэрлэл, гэрлэлт гэр бүлийн харилцаанд нөлөөлж байна.

Өнөөдөр дэлхий дахины хэмжээнд эмэгтэйчүүдийн 90%, эрэгтэйчүүдийн 80% нь 30 хүртэлх насандаа гэрлэж хүүхэд төрүүлэх явдал нь улам бүр залуу насны шинжтэй болсон. Монголд 40-50 жилийн өмнөх эмэгтэйчүүдийн төрүүлэх насыг авч үзвэл 18-50 нас зонхилж түүний бараг бүх үед энэ насыг хамарсан төрөлтийн үйл явц үргэлжилж байсан бол 1990-ээд оны үед нийт төрж байгаа хүүхдүүдийн 75% эхийгээ 30 нас хүрээгүй, эцгийгээ 40 нас хүрээгүй байхад мэндэлж байлаа. Ийнхүү хүүхэд төрөх явдал эхийгээ 30 нас, эцгийгээ 40 наснаас хойш үндсэндээ зогсож байна.

Тиймээс гэр бүл болж байгаа залуучуудыг дотор нь түрүү залуу насандаа, дунд залуу насандаа, төгс залуу насандаа гэр бүл бологсад хэмээн 3 ангилж болох юм.

**Түрүү залуу насанд** 18-21 насны залуучуудыг хамруулна. Энэ насныхны онцлог нь гэр бүл бологсад гэр бүл-хамт олон-нийгэм хэмээх гурвал сүлжээнд шилжиж эхэлдэг бөгөөд тэдэнд хуулийн өмнө үүрэг хариуцлага хүлээх чадвар, өрх гэр тэргүүлэх, анхны хүүхдээ төрүүлэх, мэргэжил эзэмших зэрэг нийгэмшлийн агуулга гүнзгийрдэг юм. Үүнээс гадна нийгмийн халамжаас аажмаар холдож бие даасан байдалд шилжихийн хамт хөдөлмөр эрхлэлтийн хэлбэрээ сонгож хуулиар сонгох сонгогдох эрхээ эдэлж эхэлдэг. Тэд энэ үед эцэг эхийн хараат байдлаас ангижрахад хүндрэлтэй, авч буй цалин хөлс нь амьдралын наад захын хэрэгцээнд хүрэлцээ муутай, анхны хүүхдээ асарч хүмүүжүүлэх, эрүүл чийрэг өсгөн бойжуулахад туршлага дутах зэрэг бэрхшээлүүдтэй байнга тулгардаг.

*Дунд залуу насанд* 22-25 насны залуучуудыг хамруулж болно. Энэ насанд гэр бүл бологсодын хувьд нийгэмшлийн зохих түвшинд хүрч аливаа ажил хөдөлмөр эрхлэхэд тавигдсан хязгаарлалтаас чөлөөлөгдөж ажил хөдөлмөрийн зохих түвшинд хүрэх арга замаа мэдэж хөдөлмөрийн хөлсний нэмэгдэл ноогдлыг хүртэх онцлогтой болдог. Тэд өөрийн болон гэр бүлийн орлогоор бие даасан амьдралд шилжиж, бусад залуу гэр бүлээс суралцах, бусад дэмжлэг туслалцаа үзүүлэхээс гадна нийгмийн шинэ харилцаанд түргэн дасан зохицож чаддаг юм.

*Төгс залуу насанд* 26-30 насны залуучуудыг хамруулна. Тэд биеийн болон оюуны хөдөлмөрт гүйцэд гаршин зүгширсэн үе байдаг бөгөөд ажил мэргэжлийн ур чадвар, дадлага туршлагыг хуримтлуулж хэрхэн амьдрах, ямар хөдөлмөр эрхэлж цаашид яаж өсөж хөгжих үндсэн сонголтуудыг хийсэн байдаг. Түүнчлэн тусдаа орон сууцтай болох, эдэлж хэрэглэх өмч хөрөнгөө бэлтгэх боломжийг бүрдүүлж чаддаг. Тиймээс өнөөдөр төгс залуу насандаа гэрлэх явдал өсөх хандлагатай байна.

Үүнээс гадна гэрлэлтийн судалгааны хамгийн гол үзүүлэлтийн нэг нь гэрлэлтийн дундаж нас байдаг тул үүнийг тодорхойлсноор тухайн улсын хүн амын гэрлэлтийн ерөнхий төлөв байдлыг дүгнэх боломжтой болдог.

Аэрлэлтийн дундаж нас улс орон бүрт харилцан адилгүй байдаг бөгөөд тухайн хүний бие физиологийн хүчин зүйлүүдээс гадна улс орны эдийн засгийн хөгжил, уламжлал, ёс заншил, хүн амын боловсролын байдал, боловсрол эзэмших хугацаа, бие даан амьдрах нөхцөл, бололцоо боломж, мэдлэг мэргэжил, хүйсийн харьцаа зэрэг олон үзүүлэлтүүдээс хамаардаг байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд хүн амын гэрлэх нас хожуусаж 1989-2000 онд гэрлэлтийн дундаж нас 2,4-2,6 жилээр нэмэгдэж, эмэгтэйчүүдийн хувьд 23,7 нас, эрэгтэйчүүдийн хувьд 25,7 насандаа гэрлэх болсон. 1990- 2000 оны хооронд гэрлэлтийн ерөнхий коэффициент 16,9-9,0 болж 47 хувиар буурсан нь гэрлэлтийн дундаж нас хойшлоход нөлөөлж байна. Мөн 15 наснаас дээш насныхан нийт хүн амд огт гэр бүл болоогүйд тооцогдож тэдний эзлэх хувийн жин нэмэгдсэн бөгөөд зөвхөн 2000 онд хүн амын 33,1 хувь буюу 3 хүний нэг нь гэрлээгүй байгаа явдал залуучууд хожуу гэрлэх болж буйг илтгэж байна.

Залуучуудын гэрлэлтийн байдал<sup>3</sup>

		1956			1989			2000		
		%	Аэргэсэн	Аэргээгүй	%	Аэргэсэн	Аэргээгүй	%	Аэргэсэн	Аэргээгүй
15-19	Эрэгтэй	100			100			100	3,2	96,8
	Эмэгтэй	100	19	81	100	9	91	100	5,5	94,4
20-24	Эрэгтэй	100	27	73	100	25	74	100	28,7	70,7
	Эмэгтэй	100	68	32	100	51	48	100	38,2	51,7
25-29	Эрэгтэй	100	61	39	100			100	66,6	31,2
	Эмэгтэй	100	82	18	100	81	15	100	74,6	20,1

Залуучуудын гэрлэлтийг насны ангиллаар аваад үзвэл 1956 онд 15-19 насны охидуудын тавны нэг, 20-24 насныхны 68% нь гэрлэж байсан бол 1989 онд энэ насны ангилалынхан 9% : 51% харьцаатай болсон байна. Харин 25-29 насны эмэгтэйчүүдийн гэрлэлтийн түвшин 1956, 1989 онд бараг адилхан болжээ. 2000 онд 15-24 насны эрэгтэйчүүдийн 83,5 хувь, эмэгтэйчүүдийн 73,1 хувь нь огт гэрлээгүй бөгөөд энэ насны бүлэгт гэрлэсэн эмэгтэйчүүд 21,9 хувийг эзлэж байгаа нь эрэгтэйчүүдийнхээс 6 пунктээр илүү байна.

Өнөөдөр гэрлэгсдийн насны зөрөө дунджаар 4-5 жил байгаагаас үзвэл эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 8,2-25,3 мян. хүнээр илүү байгаа нь гэрлэлтийн байдалд нөлөөлж байна.

<sup>3</sup> УСГ.НҮБХХ, 2000 оны хүн ам, орон сууцны тооллого. Үндсэн үр дүн.2000. УБ., 2001.

Гэрлэлтийн насны залуучуудын хүйсийн харьцаа<sup>4</sup>

Эрчүүд	Мян.хүн	Бүсгүйчүүд	Мян.хүн
15-19	133,6	10-14	158,9
20-24	123,4	15-19	131,6
25-29	109,9	20-24	122,4

Үүнээс гадна гэрлэх насны залуучуудын боловсролын түвшинг хүйсээр авч үзэхэд ихээхэн өөрчлөлт орсон байна. 1989 онд багаас дээш боловсролтой эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол харьцангуй цөөн байсан бол бага боловсролтой эмэгтэйчүүд арай илүү байв. 2000 онд энэ байдал өөрчлөгдөж дээд болон багаас дээш боловсролтой эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс давах болсон.

Гэрлэлтийн байдал (боловсролын түвшингээр)

		Гэрлээгүй						Гэрлэсэн					
		Боловсролгүй	Бага	Бүрэн бус дунд	Бүрэн дунд	Тусгай дунд	Дээд	Боловсролгүй	Бага	Бүрэн бус дунд	Бүрэн дунд	Тусгай дунд	Дээд
20-29	Эрэгтэй	73,2	63,4	50,9	52,6	39,4	41,7	25,7	35,6	47,7	46,2	59,3	57,3
	Эмэгтэй	69,7	44,9	30,5	40,8	29,6	43,1	28,1	52,8	66,6	56,6	17,0	54,3

Дээрх тоон үзүүлэлтээс үзвэл боловсролгүй залуучууд орой гэрлэх хандлагатай байгаа бөгөөд эзэмшсэн боловсрол дээшлэх тусам залуучуудын гэрлэх магадлал өндөр болж байна. Огт гэрлээгүй 20-29 насныхнаас эрэгтэйчүүдийн 73,2 хувь, эмэгтэйчүүдийн 69,7 хувь нь боловсролгүй бөгөөд гэрлэж амжаагүй байна. Энэ насны нийт эмэгтэйчүүдийн гуравны хоёр, эрэгтэйчүүдийн хоёрны нэг нь гэрлэсэн бөгөөд тусгай дунд боловсролтой эрэгтэйчүүдийн 39,4 хувь, эмэгтэйчүүдийн 29,6 хувь нь гэрлээгүй байх юм.

Эхнэр нөхрийн боловсролын түвшин, 2000 он<sup>5</sup>

Нөхрийн боловсролын түвшин	Эхнэрийн боловсролын түвшин						
	Багаас доош	бага	Бүрэн бус днд	Бүрэн дунд	Техник мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дээд
Багаас доош	48,7	6,3	2,4	0,7	1,2	0,3	0,1
Бага	27,3	58,7	13,8	4,6	6,6	2,6	0,6
Бүрэн бус дунд	15,5	22,2	61,1	32,2	29,8	20,2	7,1
Бүрэн дунд	3,1	4,7	12,2	41,2	18,8	22,4	16,0
Техник мэргэжлийн	2,2	2,5	4,3	6,1	27,6	8,2	3,1
Тусгай мэргэжлийн дунд	2,5	3,9	4,0	7,9	10,6	26,0	11,5
Дээд	0,7	1,7	2,2	4,3	5,3	20,3	61,6
Бүгд	100,0	100,0	100,0	100,0	100,0	100,0	100,0
Өөрийнхөө боловсролын түвшингээс	-	6,3	16,2	37,5	56,4	53,7	38,4

4 Х.Гүндсамбуу, Г.Чулуунбаатар. XX зууны босгон дахь Монголын залуучууд, УБ, 2001.

5 УСГ.НҮБХХ, 2000 оны хүн ам, орон сууцны тоолого. Үндсэн үр дүн. 2000. УБ.,2001.

доогуур боловсролтой хүнтэй гэрлэсэн							
Ижил боловсролтой	48,7	58,7	61,1	41,2	27,6	26,0	61,6
Дээгүүр боловсролтой	51,3	35,0	22,7	21,3	16,0	20,3	-

Эмэгтэйчүүдийн боловсрол нэмэгдэх тусам өөрөөсөө доогуур боловсролтой хүнтэй гэрлэхэд хүрч байна. Тусгай дунд мэргэжлийн боловсролтой эмэгтэйчүүдийн талаас илүү хувь (53,7 хувь) нь өөрөөсөө доогуур боловсролтой эрэгтэйтэй гэрлэсэн бол дээд боловсролтой эмэгтэйчүүдийн гуравны нэгээс илүү хувь (38,4 хувь) нь өөрөөсөө доош боловсролтой эрэгтэйтэй гэрлэсэн. Гэхдээ эдгээр эмэгтэйчүүдийн 16,0 хувь нь бүрэн дунд боловсролтой 11,5 хувь нь тусгай мэргэжлийн дунд боловсролтой нөхөртэй байна юм. Энд гэр бүлийн хүрэн дэх жендерийн асуудал хурцаар тавигдах болсон.

Нийгмийн өөр өөр бүлэг давхаргаас хоорондоо гэрлэх явдал олширч байгаа нь тухайн бүлэг давхрагынхаа нандин чанар, үнэт зүйлсийг хойч үедээ өвлүүлэхэд ач холбогдолтой юм. Гэхдээ нас, боловсрол мэргэжил, материаллаг хангамж нөхцөлийн ялгаа гэр бүлд тэгш бус харилцааг бий болгож эхнэр нөхрийг нэг нэгэндээ сэтгэл ханамжгүй байх, зөрчил маргаан гарах шалтгааныг үүсгэж болох талтай.

Манай улсын өрх гэрийн нэгэн онцлог бол нийлмэл гэр бүлийн хувийн жин нэмэгдэж байгаа явдал юм. 2000 оны хүн амын тооллогын явцад айл өрхийг төрөл хэлбэрээр нь ялган тоолсны үр дүнд нийт өрхийн 27,8 хувь нь нийлмэл өрх буюу эцэг эх нь гэр бүл болсон хүүхдүүдтэйгээ хамтран амьдардаг өрх байв. Гэр бүл болж албан ёсоор бүртгүүлсэн боловч орон сууцны боломжгүйгээс хамтдаа биш тус тусдаа амьдарч байгаа залуу гэр бүл ч цөөнгүй байна. Залуу гэр бүлийн хос хоёр зөвхөн өөр хоорондоо харилцан ойлголцох бүх талын холбоогоо бэхжүүлээд зогсохгүй боловсрол мэргэжил эзэмших, хөдөлмөрийн гараагаа эхлэх, хамт олны дунд орж ажиллах, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх зэрэг олон чухал асуудлыг шийдвэрлэх үүрэг хариуцлага хүлээдгээрээ онцлог юм. Үгөө талаар залуу гэр бүл нь гэр орны хувьд тохижих, амьдрах баталгаагаа бий болгох, эцэг эхийн хараат байдлаас ангижрах нийгмийн шинжтэй асуудлыг шийдвэрлэх үүрэгтэй болдог.

Монгол улсын төрөөс баримтлах хүн амын бодлогод гэр бүлийн хөгжлийг хангах тухай заахдаа ``гэр бүл эдийн засгийн талаар бие даан хөгжих чадавхиа дээшлүүлэх, өмч хөрөнгөө өсгөн арвижуулах аливаа шударга санаачлага, үйл ажиллагаанд төрөөс дэмжлэг үзүүлнэ`` хэмээжээ. Гэтэл улсын хэмжээнд залуу гэр бүлд амины орон сууц барих, газар тариалан, бизнес эрхлэхэд зориулан жижиг зээл олгох, залуу эцэг эхийг дэмжин туслах эдийн засаг, эрх зүйн орчин бүрэлдээгүй байгаа нь залуу гэр бүл бие дааж амьдрах, төлөвших үйл явцад хүндрэл учруулж байна. Зарим нэг компани аж ахуйн газруудаас хэрэгжүүлж байгаа орон сууцны төсөлд санхүү эдийн засгийн хувьд хөл дээрээ зогсож чадаагүй байгаа залуу гэр бүл оролцох боломжоор тааруу байдаг.

Нийгмийн өөрчлөлт шинэчлэл, өмч хувьчлалын үр дүнд гарсан ажилгүйдэл, ядуурал, архидалт, гэмт хэргийн өсөлт, хүүхдийн сургууль завсардалт зэрэг нийгмийн сөрөг үр дагавар залуу гэр бүлийн амьдралд нөлөөлж, гэр бүл салалт, үр хүүхдээ хаях, гэнүүчлүүлэх, гэр бүлийн уламжлалт ёс зүйгээ алдахад хүргэж байна. Манай орны хувьд гэрлэлт өндөр, цуцлалт харьцангуй бага байдгаараа онцлогтой. Гэвч гэрлэснээс хойш эхний 6 жилд залуу гэр бүл салж байгаа нь нийт гэр бүл цуцлалтын 38 хувийг эзэлж байна. Сүүлийн үеийн судалгаанаас харахад гэр бүлийн гишүүд нэг нэгэндээ итгэл алдарч сэтгэл хөрсөн, санхүүгийн хүндрэл бэрхшээлтэй тулгарсан, гэр бүлийн дотоод асуудалд хадмууд хэт оролцдог зэрэг шалтгаанууд гэр бүл салахад голлох үүрэг гүйцэтгэдэг байна.<sup>6</sup> Залуучуудад гэр бүлийн амьдралд системтэйгээр бэлтгэх сургалтыг хүүхэд ахуй цагаас нь эхлэж үе шаттайгаар зааж, гэр бүлийн харилцааны зүй тогтол, эхнэр нөхөр, хүүхдийн үүрэг хариуцлага, гэр

5 ``Гэр бүлийн харилцаан дахь уламжлал, шинэчлэл``. МУИС-ийн социологийн тэнхим. УБ. 2000.

бүл төлөвлөлтийн талаар шинжлэх ухааны үндэстэй мэдлэг олгож байвал гэр бүлийн хүрээн дэх гаж үзэгдэл гарах нь багасах ач холбогдолтой.

Уламжлалт гэр бүл болон гэрлэлтийн харилцаанд өөрчлөлт орж илүү ардчилсан шинэ үнэлэмж баримжаалалууд төлөвших хандлагатай болжээ. Уламжлалт гэр бүлд тэжээгчийн үүргийг ихэнхдээ эрэгтэй хүн хүлээж байсан бол өнөө үед залуу гэр бүлийн эхнэр нөхөр хоёулаа хөдөлмөрлөх болсон. Нөгөө талаас уламжлалт гэр бүлийн дотоод харилцаанд ноёлж байсан нөхөр нь эхнэрээ үг дуугүй захирах явдал арилж тэгш эрхт харилцаа руу шилжих болсон.

Ямар ч оронд залуу гэр бүлийн асуудлыг төрийн бодлогын түвшинд тавьж туслан дэмжих бодлого явуулж байдаг. Тийм учраас өнөөдөр төрөөс залуу гэр бүлийн эдийн засгийн чадавхийг бэхжүүлж, орлогыг нь дээшлүүлэх, ажиллаж хөдөлмөрлөх нийгэм, сэтгэл зүйн, эрхзүйн таатай орчинг бүрдүүлэх, гэрээрээ хөдөлмөр эрхэлж байгаа залуу гэр бүлийн нийгмийн даатгалыг хангах эрхзүйн баталгааг бий болгох, олон хүүхэдтэй болон орлого бага залуу гэр бүлийг дэмжих, тэтгэх, орон сууц, гэртэй болоход нь удаан хугацааны зээл тусламж олгох боломжийг бүрдүүлэх, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн сарын тэтгэмжийг нэмэгдүүлэх бодлого явуулах, залуу гэр бүлийг дэмжих, хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх зэрэг залуу гэр бүлийг дэмжвэл зохих үндсэн чиглэлүүдээр тодорхой үйл ажиллагаа явуулах нь чухал юм.